

ХҮРД ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж, хурлын ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцохыг хүсч байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ /, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 2 удаа зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2020 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн тоо болон хувь хэмжээнд өөрчлөлт гараагүй, 2021 оны 03-р сарын 22-ны байдлаар компанийн 135266 ширхэг хувьцааг 2020 онд 96 хүн эзэмшдэг байсан, энэ тоо хэвээр байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин хөлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудалд анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

Компанийн ТУЗ 4 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг болон удирдлагын урамшуулал олгох, компанийн хэтийн хөгжил, засаглалыг сайжруулахад зориулж шинэ залуу боловсон хүчин бэлтгэх, инженерүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж зэрэг эзэмшүүлэх, бизнес төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагааг өргөтгөх, барилга угсралтын ажлын явцтай танилцах шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

2019 онд компанийн нэгж хувьцаанд **535** төгрөг, бүгд **72,367.31** мянган төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2020 онд компанийн нэгж хувьцаанд **479** төгрөг, нийт **64,792.4** мянган төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2019 оны ажлын үр дүнд **"хангалттай"** гэсэн дүгнэлт өгснийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу удирдлагын урамшилд **28,9 сая** төгрөг олгожээ.

2020 оны компанийн удирдлагын зардлыг **375,0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **282,8** сая төгрөг болж, **92.2 сая** төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ. Энэ нь цар тахлын улмаас хил хаалттай, удирдлагууд гадаадад томиллолтоор ажиллаагүйтэй холбоотой юм.

Компани санхүүгийн хувьд мөнгөн хөрөнгө, материалын зохих нөөцийг бүрдүүлж, эдийн засгийн хүчин чадал өсөн нэмэгдэж байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгө өөрчлөлтгүй, **8** барилга байгууламж **316.049** сая төгрөг хэвээр байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд **971,68** сая төгрөг байснаа оны эцэст элэгдэл тооцоод **1128,06** сая төгрөг болж өөрчлөгджээ.

Байгууллага хүмүүсээс авах БУА-ын санхүүжилт болон авлага оны эхэнд **1,417.8** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд **10,667.4** сая төгрөгөөр нэмэгдэж, **11,393.4** сая төгрөгөөр буурч, оны эцэст авлага **1,691.8** сая төгрөг болж, авлага **274.0** сая төгрөгөөр өссөн байна.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд **1,532.5** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд **3,058.94** сая төгрөгөөр нэмэгдэж, **653.4** сая төгрөгөөр буурч, оны эцэст **3938.04** сая төгрөг болж өглөг **2,405.5** сая төгрөгөөр өссөн байна.

Бид өнгөрсөн онд **6 тэрбум 703,2 сая** төгрөгийн БУА гүйцэтгэж, **1 тэрбум 848 сая** төгрөгийн орон сууцны үйлчилгээний ажил, нийт **8 тэрбум 694 сая** төгрөгийн барилга угсралт, ажил үйлчилгээ эрхэлж **8 тэрбум 429 сая** төгрөгийн зардал гаргаж, барилга угсралтын хувьд **265,1 сая** төгрөгийн ашигтай, **1** төгрөгийн БУА-ыг **97** мөнгөөр гүйцэтгэж, барилга угсралтын хувьд **3%**-ийн ашигтай ажиллажээ.

Компанийн нийт борлуулалт 2020 онд **8 тэрбум 694** сая төгрөг бөгөөд татварын өмнөх ашиг **490.7** сая төгрөг, цэвэр ашиг **431.74** сая төгрөг байна.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт **693.89** сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд **115.2 сая** төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

2020 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны хүүг нэмэгдүүлэх болон авлага, өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна.

Компанийн ашиглалтгүй буюу илүүдэлтэй ажлын байруудыг түрээсээр ажиллуулж, 2020 онд **74.02** сая төгрөгийн түрээсийн орлого оруулсан нь өнгөрсөн оныхоос 2 дахин бага байна.

2016 онд ажлыг нь бүрэн хийж, ашиглалтад өгсөн хэд хэдэн томоохон барилгын санхүүжилт оны эхний байдлаар **358** сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас Баруун-Уртын Элит хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын **264.09** сая ₮ төгрөгийн үлдэгдэл байна.

Компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, 2020 оны бизнес төлөвлөгөөний биелэлт, ТУЗ-ийн үйл ажиллагаа тогтворжсон зэргээс харахад компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэвийн явагдаж, үүргээ биелүүлж ажилласан гэж үзэж байна.

2021 онд компанийн зорилтот үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэ оны ажлын ерөнхий чиглэл, зорилго дараах байдалтай байна. Үүнд:

2021 онд Бизнес төлөвлөгөөгөөр **5,54** тэрбум төгрөгийн борлуулалт, **340.6** сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн.

2021 онд барилга угсралтын ажлаа гүйцэтгэхээс гадна компанийн гадаад харилцааг хөгжүүлэх, гадаадын түнштэй хамтарсан сантехникийн материалын

худалдаа эрхлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орон сууц барих ажлыг үргэлжлүүлэх бодлого боловсруулж ажиллана.

Компанийн “Хүрд-Орон сууц” салбар одоогоор 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр тогтвортой сайн ажиллаж байна.

Компанийн бетон эдлэлийн болон төмөр хийцийн цехийг бие даасан үйлдвэр ХХ Компани болгохоор төлөвлөсөн ч хэрэгжээгүй л байна.

Компанийн барьж ашиглалтанд оруулсан 15 давхар 84 айлын орон сууцыг борлуулна.

Компани 2020 онд **8 тэрбум 694** сая төгрөгийн БУА, ажил үйлчилгээ гүйцэтгэж, **8.0 тэрбум 694 сая** төгрөгийн борлуулалт хийж **431,74** сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2020 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж, төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлснийг харуулж байна.

Компанийн 2020 оны удирдлагын зардлын зарцуулалт, инфляцийн түвшинг харгалзан 2021 оны удирдлагын зардлыг **375,0 сая** төгрөгөөр төлөвлөж байна.

Ажлын үр дүн, компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мөн 2021 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлуулахаар хуралд хэлэлцүүлж байгаад санал бодлоо илэрхийлж баталж өгөхийг хүсье.

Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хүрд ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл